



## МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 10 дугаар сарын 09-ний өдөр


№ 01

Улаанбаатар хот

### Компанийн зарласан хувьцааны тоог нэмэгдүүлж, нэмж гаргасан хувьцааг олон нийтэд санал болгох тухай

Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2.2 дахь заалт, 38 дугаар зүйлийн 38.8 дахь хэсэг, 42 дугаар зүйлийн 42.4 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.3, 62.1.8 дахь заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 16 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 244 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 336 дугаар тогтоол, “Монголын цахилгаан холбоо” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2, 5.3 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 7.8.3 дахь заалт, 2023 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн зарласан болон гаргасан энгийн хувьцааны тоо нийт 25,870,276 (хорин таван сая найман зуун далан мянга хоёр зуун далан зургаа) ширхэг болохыг дурдсугай.
2. Компанийн зарласан энгийн хувьцааны тоог нийт 37,120,131 (гучин долоон сая нэг зуун хорин мянга нэг зуун гучин нэг) ширхэг болгон нэмэгдүүлсүгэй.
3. Компанийн одоогийн гаргасан 25,870,276 (хорин таван сая найман зуун далан мянга хоёр зуун далан зургаа) ширхэг энгийн хувьцаан дээр нэмж, зарласан энгийн хувьцаанаас нэг бүр нь 100 (нэг зуу) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 11,249,855 (арван нэгэн сая хоёр зуун дөчин есөн мянга найман зуун тавин тав) ширхэг энгийн хувьцааг нийтэд санал болгон нээлттэй арилжаалахаар нэмж гаргасугай.
4. Энэхүү шийдвэрийн дагуу нэмж гаргаж буй 11,249,855 (арван нэгэн сая хоёр зуун дөчин есөн мянга найман зуун тавин тав) ширхэг энгийн хувьцаа нь Компанийн нийт гаргасан 37,120,131 (гучин долоон сая нэг зуун хорин мянга нэг зуун гучин нэг) ширхэг энгийн хувьцааны 30.31 хувьтай тэнцэх бөгөөд нэмж гаргах хувьцааны олон нийтэд санал болгох зах зээлийн үнийг хараат бус бизнесийн үнэлгээний тайланг үндэслэн тогтоох эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлд олгосугай.
5. Монгол Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 244 дүгээр тогтоолоор нэмж гаргасан хувьцааг олон нийтэд санал болгохоор шийдвэрлэсэн зарчмыг баримтлан компанийн одоогийн хувьцаа эзэмшигч нь нэмж гаргасан хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг хэрэгжүүлэхгүй байхаар шийдвэрлэсүгэй.







## МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 10 дугаар сарын 09-ний өдөр

№ 02

Улаанбаатар хот

### Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.16 дахь заалт, Монголын цахилгаан холбоо ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 7.8.9 дэх заалт, 2023 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн одоогийн хувьцаа эзэмшигчид нь нэмж гаргасан хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг хэрэгжүүлэхгүй байхаар шийдвэрлэсэнтэй холбогдуулан 2023 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 02 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



С.НЯМБАЯР



## МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 10 дугаар сарын 09-ний өдөр

№ 03

Улаанбаатар хот

### Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлж, сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.4 дэх хэсэг, “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.6, 7.10, 7.16, 7.18 дахь заалт, 2023 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд нэр дэвшигчдээс кумулятив аргаар хамгийн олон санал авсан Б.Төрбат, Ц.Баяр-Эрдэнэ нарыг 2023 оны 10 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр сонгосугай.
2. Т.Лхагвасүрэн, Г.Эрдэнэбулган нарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний үүрэгт ажлаас 2023 оны 10 дугаар сарын 09-ний өдрөөр тасалбар болгон чөлөөлж, бүрэн эрхийг нь дуусгавар болгосугай.
3. Компанийн үйл ажиллагааг үр ашигтай удирдан зохион байгуулж, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу ажиллахыг сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



С.НЯМБАЯР